БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ДЭС ТҮШМЭЛИЙН АНГИЛЛЫН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛЫН АЖЛЫН БАЙРНЫ
СУЛ ОРОН ТООГ НӨХӨХ ИРГЭДИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ТӨРИЙН АЛБАНЫ МЭРГЭШЛИЙН ШАЛГАЛТЫН ТУХАЙ

Нэг. Мэргэшлийн шалгалтын зорилго

Баян-Өлгий аймгийн нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог анх орох иргэдээс өрсөлдүүлэн шалгаруулж нөхөхөд төрийн албаны мэргэшлийн шалгалтын зорилго оршино.

“Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”, “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ыг Төрийн албаны зөвлөлийн **www.csc.gov.mn** гэсэн цахим хуудсанд тавьсан бөгөөд бүртгүүлэх иргэд энэхүү журамтай заавал танилцсан байна.

Хоёр. Мэргэшлийн шалгалтын бүртгэл, зардал

- Зарлагдаж буй сул орон тоонд тухайн албан тушаалд **тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадвар** болон тусгай шаардлагыг хангасан, энэ албан тушаалд ажиллахыг хүссэн иргэнийг бүртгэнэ.
- Тус аймгийн нутгийн захиргааны байгууллагаас зарласан төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх иргэнийг сонгон шалгаруулах мэргэшлийн шалгалтад орохыг хүссэн иргэдийг тус аймгийн Засаг даргын Тамгын газар дээр **2015 оны 03 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд 10.00-17.00** цагийн хооронд бүртгэнэ.
- Бүртгүүлсэн иргэдэд зориулсан шалгалтын зохион байгуулалт, шалгалт өгөх газар, хуваарь, цахим шалгалт өгөх семинар /зааварчилга/-ыг Салбар комисс тус аймгийн Засаг даргын Тамгын газар дээр **2015 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 16.00** цагт өгнө.
- Мэргэшлийн шалгалтад орох иргэн шалгалттай холбогдох зардлыг өөрөө хариуцах бөгөөд мэргэшлийн шалгалт өгөх иргэний шалгалтын үйлчилгээний зардал **6 000 /Зургаан мянган/** төгрөг байна

Гурав. Бүртгүүлэх иргэн дараахь бичиг баримтыг бүрдүүлнэ

- Төрийн албан хаагчийн анкет (Төрийн албан хаагчийн анкетыг маягт N1-ийн дагуу бүрэн бөглөсөн байх);

- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/-ийн эхийг нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт;
- Мэргэшүүлэх сургалтанд хамрагдсаныг гэрчлэх баримт бичгийн эх хувийг хуулбарын хамт;
- Иргэний үнэмлэхний эх, хуулбарын хамт;
- “4 х 6”-гийн хэмжээний цээж зураг 2 хувь;
- Ажилласан хугацаа болон ажил эрхлэлтийг гэрчлэх баримт /Нийгмийн даатгал, хөдөлмөрийн дэвтэр/-ийн эх хувийг хуулбарын хамт
- Шалгалтын үйлчилгээний төлбөр

Дөрөв. Шалгалтын хуваарь

- **2015 оны 03 дугаар сарын 26-ны өдөр** шалгалтыг доорхи байдлаар зохион байгуулна.

1. **Ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох шалгалт**
2. **Ур чадварын түвшин тогтоох шалгалт** /Ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох шалгалтад тэнцсэн иргэн өгнө/
3. **Мэдлэг, хандлага, зан үйлийг тодорхойлох шалгалт** /Ур чадварын түвшин тогтоох шалгалтад тэнцсэн иргэн өгнө/

- **Шалгалт авах газар, хуваарийг** бүртгүүлсэн иргэдийн тооноос хамааруулан **2015 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 16.00** цагт Засаг даргын Тамгын газар дээр мэдээлнэ.
- Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгөх иргэд **Иргэний үнэмлэхтэйгээ** ирнэ.

Тав. Мэдээлэл лавлагаа

Мэргэшлийн шалгалттай холбоотой асуудлаар тус аймгийн ЗДТГ-ын 70422982, 99426633 дугаарын утсаар холбогдож лавлагаа авч болно.

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ТУШААЛЫН СУЛ ОРОН ТОО БОЛОН АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

№	Байршил	Захиалга өгсөн байгууллага	Нэгжийн нэр	Албан тушаалын			Ажлын байранд тавигдах шаардлага						
				Ангилал	Нэр	Хариуцсан асуудал	Орон тоо	Болох срол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага	Ур чадвар	Тусгай шаардлага
1	Баян-Өлгий	Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс	Нийгмийн халамж, хүн амын асуудал хариуцсан алба	Дэс түшмэл ТЗ-5	Мэргэжилтэн	Толбо сум хариуцсан нийгмийн халамжийн	1	Бакалавр	Ня-бо эдийн засагч, эрх зүйч, нийгмийн ажилтан		Мэргэжлэрээ ажилласан байх	Нийгмийн эмзэг бүлгийн иргэдтэй ажиллах, мэргэжлийн сургалт зохион байгуулах, судалгаа дүн шинжилгээ хийх, бодлогын баримт бичиг боловсруулах, харилцааны соёлтой, багаар ажиллах, компьютерийн өргөн хэрэглээний программ ажиллах чадвартай байх.	ТАХ-ийн ёс зүйн хэмжээг сахих зарчимч, байгууллагын нууцыг хадгалдаг чадвартай байх
2	Баян-Өлгий	Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс	Нийгмийн халамж, хүн амын асуудал хариуцсан алба	Дэс түшмэл ТЗ-5	Мэргэжилтэн	Алтанцөгц сум хариуцсан нийгмийн халамжийн	1	Бакалавр	Ня-бо эдийн засагч, эрх зүйч, нийгмийн ажилтан		Мэргэжлэрээ ажилласан байх	Нийгмийн эмзэг бүлгийн иргэдтэй ажиллах, мэргэжлийн сургалт зохион байгуулах, судалгаа дүн шинжилгээ хийх, бодлогын баримт бичиг боловсруулах, харилцааны соёлтой, багаар ажиллах, компьютерийн өргөн хэрэглээний программ ажиллах чадвартай байх.	ТАХ-ийн ёс зүйн хэмжээг сахих зарчимч, байгууллагын нууцыг хадгалдаг чадвартай байх

3	Баян-Өлгий	Мэргэжлийн хяналтын газар	Хилийн мэргэжлийн хяналтын хэлтэс	Дэс түшмэл ТЗ-6	Мэргэжилтэн	Хилийн эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналт хариуцсан байцаагч	1	Бакалавр	Эрүүл ахуйч, халдвар судлагч их эмч	Мэргэжлээр ээ мэргэшсэн байх	Мэргэжлээр ээ 3-аас доошгүй жил ажилласан байх	Зохион байгуулах, баримт бичиг боловсруулах, Монгол хэл бичгийн дүрмийг хэрэглэж чаддаг байх,компьютерийн өргөн хэрэглээний программ ажиллах чадвартай байх.	Байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах, Хөндлөнгийн нөлөөнд үл автах, Системийн дүн шинжилгээ хийх
4	Баян-Өлгий	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс	Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс	Дэс түшмэл ТЗ-5	Мэргэжилтэн	Хүүхдийн хөгжил, хөтөлбөр хариуцсан	1	Бакалавр	Нийгмийн ажилтан, гадаад харилцааны ажилтан	Хүүхдийн хөгжлийн чиглэлээр дипломын дараах сургалтанд хамрагдсан байх	мэргэжлээр ээ 1-ээс доошгүй жил ажилласан байх	Зохион байгуулах, баримт бичиг боловсруулах, Монгол хэл бичгийн дүрмийг хэрэглэж чаддаг байх, компьютерийн өргөн хэрэглээний программд ажиллах чадвартай байх.	Байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах, Хөндлөнгийн нөлөөнд үл автах, Системийн дүн шинжилгээ хийх
5	Баян-Өлгий	Монгол-Алтайн нурууны УТХГ-ын хамгаалалтын захиргаа	Хамгаалалтын захиргаа	Дэс түшмэл ТЗ-5	Мэргэжилтэн	Мэдээлэл, сургалт сурталчилгаа, аялал жуулчлалын асуудал хариуцсан	1	Бакалавр	Аялал жуулчлалын чиглэлийн мэргэжилтэй,	Англи, орос хэлний сургалтанд хамрагдсан байх	Мэргэжлээр ээ 3-аас доошгүй жил ажилласан байх	Орос, Англи хэлээр чөлөөтэй ярьж чаддаг байх. Компьютерийн зохих мэдлэгтэй байх	ТАХ-ийн ёс зүйн хэмжээг сахих зарчимч, байгууллагын нууцыг хадгалдаг чадвартай байх
6	Баян-Өлгий	Монгол-Алтайн нурууны УТХГ-ын хамгаалалтын захиргаа	Хамгаалалтын захиргаа	Дэс түшмэл ТЗ-5	Мэргэжилтэн	Байгалийн нөөцийн асуудал хариуцсан	1	Бакалавр	Байгаль орчны чиглэлийн мэргэжилтэй байх.	Дипломын дараах сургалтанд хамрагдсан байх,	Мэргэжлээр ээ 3-аас доошгүй жил ажилласан байх	Багаар ажиллах чадвартай гадаад хэл, компьютерийн зохих мэдлэгтэй	ТАХ-ийн ёс зүйн хэмжээг сахих зарчимч, байгууллагын нууцыг хадгалдаг чадвартай байх

ТӨРИЙН АЛБАНЫ МЭРГЭШЛИЙН ШАЛГАЛТЫН ТӨВ КОМИСС